



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 158/БДА-2024/03/1/А-СГА-043

Өлгий

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Биеийн тамир, спортын газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн баталгаажуулах аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Биеийн тамир, спортын газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн А/85 дугаар тушаалаар нягтлан бодогчид 1,471,000 төгрөгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар өөрчлөлтгүй дүгнэлт авсны балансын урамшуулал олгож, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны "Журам батлах тухай" 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, даатан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1.Төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшууллыг холбогдох хууль, журам зөрчиж тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн олгохгүй байх;

2.Зөрчлийг арилгаж албан шаардлагын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;

3.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биеийн тамир, спортын газрын дарга /Х.Хайнар/, нягтлан бодогч /Х.Уатхан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР



М.АЙНУР

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

¹ Баян-Өлгий аймаг. Өлгий сум. 5 дугаар баг. ЗДТГ-ын байр 1 дүгээр давхар. Утас: 70422954, 70422930



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 70/ББА-2025/031/КА-СТА-001

Өлгий

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аймгийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн баталгаажуулах аудитаар төрийн захиргааны албан хаагчдад олгосон нэг удаагийн мөнгөн урамшууллын тооцоог шалгаж үзэхэд дараах дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1.Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам нэг удаа олгох мөнгөн урамшууллын тооцоогоор Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2024 оны 05 сарын 08 өдрийн тушаалаар Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга Х.Хайнард 9,539,500 төгрөгийн мөнгөн урамшуулалаас 953,950 төгрөгний хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй олгосон байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Татварын хууль тогтоомжид хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно", 6.1.19-д "суутган төлөгч" гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг", 28 дугаар зүйлийн 28.7-д "Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана.",

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно", 6.3.1-д "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 21-р зүйлийн 21.1-д "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар,..... тооцон албан татвар ногдуулна", 25 дугаар зүйлийн 25.1-д "Энэ хуулийн 4.1.11-д заасан суутган төлөгч албан татвар ногдуулахад доор дурдсан журмыг баримтална", 25.1.1-д "энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам нэг удаа олгох мөнгөн урамшуулалаас суутгаагүй 953,950 төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг хавсралтад заасан нэр бүхий албан хаагчдаар нөхөн төлүүлэх;

2. Төлбөрийн актыг төсвийн орлого болгож аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан дахь 100020051005 тоот дансанд 2025 оны 10 дугаар сарын 30-ны дотор барагдуулах;

3.Актын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 30-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт² ирүүлэхийг Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга /Х.Хайнар/, нягтлан бодогч /Х.Уатхан/ нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

АХЛАХ АУДИТОР



М.АЙНУР

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Ж.АЙГҮЛ



² Баян-Өлгий аймаг. Өлгий сум. 5 дугаар баг. ЗДТГ-ын байр 1 дүгээр давхар. Утас: 70422954, 70422930

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын
газрын 2025 оны 2-р сарын 25-ны өдрийн
...70... дугаар актын хавсралт



№	Ажиллагсдын нэрс	Албан тушаал	Мөнгөн урамшууллын дүн	ХХОАТ суутган төлөх актын мөнгөн дүн
1	Х.Хайнар	Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга	9,539,500	953,950
Нийт дүн			9,539,500	953,950

Хавсралт гаргасан: Ахлах аудитор

М.Айнур

Танилцаж зөвшөөрсөн:

дарга

Х.Хайнар

Нягтлан бодогч

Х.Уатхан